



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Халдварт өвчин судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 26,070,000.00 (хорин зургаан сая далан мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 88-33 УБП улсын дугаартай тээврийн хэрэгслийг хавсралтад заасны дагуу төрийн өмчийн данс бүртгэлээс хасч, засан сэлбэн ашиглах зорилгоор Ховд аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захирал Ц.Билэгтсайхан, Ховд аймгийн орон нутгийн өмчийн газрын дарга Б.Энхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг орон нутгийн өмчит хуулийн этгээд (Ховд аймгийн Шинэ Ховд Баруун бүсийн хөгжлийн корпораци ОНӨААТҮГ)-д эзэмшүүлэх, засан сэлбэн ашиглах, үнийг шинэчлэн тогтоож данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123006893

2-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн
336 дугаар тогтоолын хавсралт

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ТӨРИЙН ӨМЧИЙН ДАНС БҮРТГЭЛЭЭС ХАСЧ, ХОВД АЙМГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашины марк, Зориулалт.	Улсын дугаар	Арлын дугаар	Үйлдвэрлэсэн (ашиглалтад) орсон огноо	Нийт гүйлт (км)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Суудлын автомашин Ниссан пикап	88-33 УБП	JN1CJUD22Z0093782	2008/2008	186,000	26,070,000.00
НИЙТ ДҮН						26,070,000.00 (хорин зургаан сая далан мянга)